



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 92

Номгон

“Цэвэр хот” ХХК-ний Төлөөлөн
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Цэвэр хот” ХХК-ний дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Цэвэр хот” ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Д.Ууганцэцэг – Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Г.Хоролсүрэн - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Э.Энхбат - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Д.Ганбаатар - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ж.Хүрэлбаатр - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Баянхонгор сумын Засаг дарга

Г.Цэдэндамбаа – Иргэний төлөөлөл

2. Компанийн дотоод журам, бүтэц орон тос, цалингийн санг холбогдох хуулийн дагуу шинэчлэн баталж, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116759



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 93

Номгон

“Баянхонгор-Нью майнинг” ХХК-ний
төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор-Нью майнинг” ХХК-ний дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Нью майнинг” ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Д.Энхтөр–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Э.Цэнд–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Б.Батсуурь–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Б.Батбаяр–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Д.Мөнхсайхан–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

2. Компанийн дотоод журам, бүтэц орон тоо, цалингийн санг холбогдох хуулийн дагуу шинэчлэн баталж, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116749



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 94

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 128 дугаар тогтоолыг
хүчингүй болгох тухай

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын иргэдээс ирсэн хүсэлт, мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Батбаяраас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 128 дугаар тогтсолыг батлахдаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн саналыг тусгаагүй, сумын иргэдээс авсан санал асуулгын дүнг харгалзан үзээгүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.12 дахь заалтыг зөрчсөн тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 128 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Баян-Өндөр сумын нутагт орших "Хүслэнтэй Амангол" нэртэй 6373,82 га талбайг аймгийн тусгай хэрэгцээнд эргүүлэн татсугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хуулийн дагуу нөхөн төлбөрийн тооцоог гаргаж ирүүлэхийг "Эпидот" ХХК-д даалгасугай.
4. Тогтоолыг Ашигт малтмалын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116951



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 95

Номгон

Аймгийн Хоршоологчдын холбооны
үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх,
санал дүгнэлт гаргах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Хоршоологчдын холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Баярсайхан–Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хорооны дарга

Гишүүд: Б.Нармандах–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

С.Рэнцэндагва–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Д.Уранчимэг–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Ж.Баттөр – Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

С.Анхбаяр – Аймгийн Цагдаагийн газрын Эдийн засгийн ахлагч төлөөлөгч

О.Бямбатогоо – Иргэний төлөөлөл

2. Шалгалтын дүнг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116763